

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2025 оны 12 дугаар сарын 12

Пионер толгой

№	Түвшин	Салбар /ТЭЗ Хөтөлбөрийн нэр		Үр дүн, үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилгот түвшин	Хэрэгжилтийн хувь /хүрсэн түвшин/	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн гүйцэтгэлийн хувь	Хэрэгжилт тайлбар
		Он	түвшин											
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	
Салбарын үр дүн : Сурагчдын сурлагын үнэлгээг суурь түвшнээс 5 хувиар ахиулна														
1	50	АЗДУАХ Т 2.3.1.2	Багшийн чадварын түвшинг дээшлүүлнэ. Чадварлаг хэмжээний хэрэгжүүлэх зардал.	ур хувиар 5 багш арга төлөвлөгөө	Хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилт	Хувь	2024	50	100	0%	20.0			Багш бүр өөрийн хөгжлийн төлөвлөгөөг жилээр боловсруулан ажиллалаа. Багш ажлын байранд хөгжих үйл ажиллагааг заах аргын нэгдлийн төлөвлөгөө, улирлын ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. У-15 аварга шалгаруулах тэмцээний мөнгөн медаль, нийт тэмцээнд оролцсон 37 сурагч, Заг сумд хангайн бүсийн аварга шалгаруулах У-10,14,15 насны ангилалын тэмцээнд 28 сурагч оролцож, У-15 насны тамирчид хүрэл медаль хүртсэн. Жюу-Жицү-гийн улсын аваргын хүрэл медаль 1, аймгийн аварга шалгаруулах тэмцээнээс 4 алт, 1 мөнгө, 2 хүрэл, 1 шилдэг тамирчин, 1 хүрэл медаль хүртсэн амжилттай. Бууцагаан сумд болсон мэргэжлийн багшийн тэмцээнд хөгжмийн багш тэргүүн байр эзэлсэн.

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1													Уралдаан тэмцээнд бэлтгэсэн шавь нараа амжилттай оролцуулсанд багш нарт 1-2 сар цалингийн ур чадварын нэмэгдэл олгосон. 2025 оны гүйцэтгэлийн үнэлгээгээр 23 багш, 416 сурагч шалгагдснаас 1-р түвшинд 2, 2-р түвшинд 7, 3-р түвшинд 6, 4-р түвшинд 4, 5-р түвшинд 4 багш үнэлэгдсэн. Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр сургуулийн дундаж гүйцэтгэл 81.91% болж өссөн үзүүлэлттэй. Чадварлаг багш арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 95%-тай. Үр дүнтэй 100%
2	АЗДУАХ Т 2.3.2.6		Сургалтын орчны стандарт үзүүлэлтүүдийг дээшлүүлнэ. Гурванбулаг сумын сургуулийн дотуур байрны засварын ажлыг эхлүүлэх.	Гүйцэтгэл	Хувь	2023	20	100	0	52.50			Аймгаас эрх шилжин ирсэн Дотуур байрны их засварын ажлыг гүйцэтгэгч "Гал гэрэл констракшн" ХХК 677 сая төсөвт өртөгтэйгээр засварлаж, аймгийн ГХБХБГазар, БОХБХ-ийн хамтарсан ажлын хэсэг хүлээн авч, ашиглалтад орсон. Үр дүнтэй 100%
Салбарын үр дүн: Нийт усны хэрэглээнд эзлэх цэнгэг усны хэрэглээг 9.6%-иас хэтрүүлэхгүй.													
3	АХТЖҮЧ- 6.1.7, АЗДУАХТ 3.2.2.1, 3.2.2.2, 3.2.2.3		Дэлхийн усны өдөр болон байгаль орчны салбарын тэмдэглэлт өдрүүдээр сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах.	Сургалтад Хамрагдсан	Тоо	2023		100	11.50				Энэ онд нийт 8 удаагийн сургалт зохион байгуулж 280 иргэн, 56 сурагч, 3 сэдвээр 450 ширхэг гарын авлага тараасан. 1 удаагийн тэмцээн уралдаан зохион байгуулж 500000 төгрөг зарцуулсан. Үр дүнтэй 85%
4	0		Гурванбулаг сумын ундны усны машины засварын ажлыг хийж гүйцэтгэх.	Гүйцэтгэл	Хувь	2023		100	20.0	20 сая	20 сая	100%	Улаанбаатарт мотор, явах эд анги, дугуй, аккумулятор, компьютер, бусад засварыг хийж 20 сая төгрөг зарцуулсан. Усны машин хэвийн үйл ажиллагаатай байна. 2026 оны төсөвт шинэ усны машин худалдаж авахаар 130 сая төгрөг төсөвлөсөн. Үр дүнтэй 100%

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
5 0	АЗДУАХТ 2.1.7.2.		Гурванбулаг суманд ахуйн үйлчилгээний төв байгуулах.	Гүйцэтгэл	Хувь	2023	0	100	150.00				Ахуй үйлчилгээний төвийн зураг төсвийг хийлгэж 1300000000 /нэг тэрбум гурван зуун сая/ төгрөгийн өртөг бүхий тендер аймагт зарлагдаж, гүйцэтгэх аж ахуй нэгж нь шалгарсан боловч улсын төсөв хямарсантай холбоотой, төндэр цуцлагдсан. Үр дүн хүлээгдэж байгаа 70%
6 30	АЗДУАХТ 2.1.7.3, 2.1.7.10, 2.1.7.11,		Баянбулаг, Гурванбулаг сумдын ундны эх үүсвэрийн усан сан байгуулах.	Гүйцэтгэл	Хувь	2023	30	100	188.51		167 сая	7 0 %	Ундны эх үүсвэрийн усан сангийн барилга 167 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр баригдаж, хүлээлгэн өгч, ашиглалтанд оруулсан. Үр дүнтэй 100%
Салбарын үр дүн: Үндэсний соёлын дархлааг 66 хувьд хүргэнэ.													
7			Үндэсний өв тээгчдийн 5 хувиар Залуучуудын дэмжих үйл зохион байгуулах. соёлын тоог нэмэгдүүлнэ. хөгжлийг ажиллагаа зохион байгуулах.	Зохион байгуулсан үйл ажиллагаа	Тоо	2024	0	100	0				Энэ онд "Хурдан морины уяа сойлого" 2, "Морь бөхийн цол дуудах" 1, оршуулгын зан үйл 1, мал амьтан ханаж, хатгах өвөөр 1 нийт 5 хүн өвлөн уламжлагч бүртгэгдсэн. Сумын залуучуудын холбоотой хамтран "Хар усан голын жавар" Урлаг спорт, соёлын өвийн олон талт арга хэмжээг зохион байгуулж нийт 528 иргэн хамрагдсан. Баянхонгор аймгийн Заг суманд Хангайн бүсийн залуучуудын чуулга уулзалтанд 25 залуучууд 10 төрлийн тэмцээн уралдаанд оролцож хамтлаг бүжгийн төрөлд тэргүүн байр эзэлсэн. SDY залуучуудын холбооны хангайн бүсийг аймгуудын зөвлөгөөнд 2 залууг оролцуулсан. Үр дүн хүлээгдэж байгаа 80%
Салбарын үр дүн : Орчны эрсдэлийг суурь түвшнээс 3 хувиар бууруулна													
8 50	АЗДУАХТ 3.1.2.12		Бүх нийтийн эрсдэлээс сэргийлэх, ойлголт, тэжээлийн нөөц бүрдүүлэх. гамшгийн урьдчилан даван түрүүлэх түвшинг нэмэгдүүлнэ. Өвс бүрдүүлэх.	Нөөц бүрдүүлэлт	хувь	2023	100	100	0	100.0			Сумын нөөцөд 96 тн өвс, 44.4 тн тэжээл, малчдын гар дээр 174тн өвс, 9.3 тэжээл, .68 хужирыг тус тус нөөцөлсөн. Үр дүнтэй 100%

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
9	83	АЗДУАХТ 4.1.9.1	Гамшгаас хамгаалах иж бүрэн, команд штабын сургууль, Аймгийн Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэг хийх	Гүйцэтгэл	Хувь	2023	83	88	0	10.0	.	.	Сумын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн нөөц хангалтанд 6.8 сая төгрөг зарцуулсан. Аймгийн Онцгой байдлын газартай хамтран гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага сургуулийг 4 сард зохион байгуулж, тус сургуульд сумын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн 96 албан хаагч, сайн дурын хэсгүүд, 523 иргэнийг татан оролцуулсан. Дадлага сургуулийн үнэлгээг 97,6% буюу дүүрэн хангалттай гэсэн үнэлгээ авсан. Үр дүнтэй 100%
Салбарын үр дүн : Хүнсний аюулгүй байдлыг 7.6 хувиар сайжруулна.													
10	50	АЗДУАХТ 2.1.6.6	Жижиг дунд Үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг 5 хувиар нэмэгдүүлнэ. Үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг дэмжих зорилгоор хавар, намрын улиралд үзэсгэлэн худалдааг зохион байгуулах.	Зохион байгуулсан үзэсгэлэн худалдааны тоо	Тоо	2022	1	3	-	20.0	.	.	"Намрын ногоон өдрүүд", "Цагаан сар" үзэсгэлэн худалдаанд Цагаан идээ, гар урлал, үндэсний дээл хувцас гэсэн төрлүүдээр 4 иргэн оролцож 3.000.000 төгрөгийн борлуулалт хийсэн Үр дүнтэй 100%
Салбарын үр дүн: Стандартын шаардлага хангасан хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг 22.5 хувиар нэмэгдүүлнэ.													
11	0	АЗДУАХТ 3.1.2	Малын үзлэг бүртгэлжүүлэлт хийж гүйцэтгэх.	Гүйцэтгэл	Хувь	2023	0	100	-	20.0	.	.	Сумын Засаг даргын 2025 оны "Бог малын үзлэг ангилалтын ажлыг зохион байгуулах тухай" 68 дугаар захирамжийн дагуу Бог малын хээлтүүлэгчийн 2 суурьт Мал эмнэлгийн тасаг, хөдөө аж ахуйн тасаг, багийн Засаг дарга нартай хамтран ажиллаж нийт 413 Бог малын хээлтүүлэгчид жигнэлт, хэмжилт хийж эзэмгжүүлж бүртгэлжүүлээ. Үр дүнтэй 100%

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
12	0	АЗДҮА ХТ 3.1.2	Нийт өндөр малын хувийг нэмэгдүүлнэ. зохиомол ажлыг хийж гүйцэтгэх мал ашиг 10 Бод хээлтүүлэг хийх	Таргасан төлийн тоо	Тоо	2022	0	100	-	20			Баталгаажсан үүлдэр омгийн малыг сайжруулагчаар ашиглаж ашиг шимийн чиглэлээр бүсчлэн үржүүлэх бодлогын хүрээнд хонин сүргийг Баяд үүлдэр болон Баянбулаг нутгийн хониор, ямаан сүргийг Бөмбөгөр омгийн ухнаар сайжруулах бодлого барин ажиллаж байна. Тус сум нь өндөр ашиг шимт мал өсгөн үржүүлэх зорилгоор аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 3 өрхийн 10 монголын үнээнд зохиомол хээлтүүлэг хийлгэх хүсэлт ирсний дагуу захиалгыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн боловч хийгдээгүй. Үр дүн хүлээгдэж байгаа 70%
Салбарын үр дүн : Гэмт хэрэг, зөрчлийг 3.3 хувиар бууруулна.													
1	7	АЗДҮАХТ	Гэмт илрүүлэлтийг нэмэгдүүлнэ. төслийн камержуулалтын ажлыг хийж гүйцэтгэх.	Гүйцэтгэл	Хувь	2023	0	70	-	80			2025 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө 45,505,000 төгрөгөөр "Арх Дата" ХХК камержуулалт 12 метр өндөр, 400 ватт 8 талтай тэжээлийг агаараас авсан гэрэлт цамхагийн хийсэн. Цамхаг бүрт RTZ 360°C хөдөлгөөнт эргэдэг камер 1ш, чиглэлийн камер 3ш, 400вт лед гэрэл 8ш, 2710м шилэн кабелиар холбогдсон камерын дуу, дүрс хангалттай, чанарын шаардлагын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгсөн. Камержуулалтын хүрээнд аймгийн Цагдаагийн газрын хяналтын нэгдсэн системд холбогдсоноор Сумын төвийн аюулгүй байдлын түвшин дээшилж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх боломж нэмэгдэн, ногоон бүсийн шаардлагыг хангаж ажиллах нөхцөл бүрдсэн. Үр дүнтэй 100%
3	0	4.1.3.1											

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Салбарын үр дүн: Төрийн бүтээмжийн сэргэлт													
14	0		Бодлогын хэрэгжилтийн зохицуулалтын үр нөлөөг 20 хувиар нэмэгдүүлнэ Шаардлагатай сумдын хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулах.	Хэрэгжилтийн хувь	Хувь	2023	0	100	?	500.0	.	.	Сумын орон нутгийн хөгжлийн сангаас 100 сая, аймгийн ОНХ сангаас 100 сая төгрөг шийдвэрлэж сумын хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын тендерийг аймагт 5 удаа зарласан боловч гүйцэтгэх аж ахуй нэгж оролцоогүй. 2026 онд аймгийн төсөвт 150 сая, сумын төсөвт 50 сая төгрөг төсөвлөсөн. Үр дүн хүлээгдэж байгаа 70%
15	0	АЗДУАХТ 4.1.5.1	Иргэн, хуулийн этгээдийн татварын албаны мэдээллийн баазад бүртгэлтэй болон бүртгэлгүй үл хөдлөх эд хөрөнгийн татвар ногдох үнэлгээг хянаж, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх	Орлогын гүйцэтгэл	Сая я.т өг	2022	523.5	2.2 Тэрбум	?	20.0	.	.	Сумын Засаг даргын 2025 оны 06 сарын 17-ны өдрийн А/78 дугаар захирамжаар Үл хөдлөх хөрөнгийн тооллого зохион байгуулах ажлын хэсэг гарч Удирдамжийн дагуу тооллогыг чанартай зохион байгуулан бүх үл хөдлөх хөрөнгийг тооллого хийж хяналтанд авч татварт бүртгүүлэн ногдлыг үүсгэн татварын төлүүлж төсөвт 6645,7-132,9 хувьтай төлөвлөгөөг давуулан биелүүлэн ажилласан. Үр дүнтэй 100%
16	0	АЗДУАХТ 4.1.4.1	Суралцагч аймаг" төсөл ажлыг хэрэгжүүлэх.	Төсөлийн хэрэгжилтийн хувь	Хувь	2023	0	100	?	10.0	.	.	Суралцагч аймаг төсөлт арга хэмжээний хүрээнд суралцагч сум төлөвлөгөө гарган, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар 56 удаагийн сургалт, зөвлөгөөн эвент арга хэмжээг зохион байгуулж, 1600000 төгрөгийг зарцуулсан. Тайлан мэдээг Насан туршийн боловсролын төвд хүргүүлсэн. Үр дүнтэй 100%

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Салбарын үр дүн: Батлан хамгаалах чадавхыг бэхжүүлнэ.													
17	0	Зөвсэгт хүчний цэргийн бэлэн байдлыг нэмэгдүүл нэ Цэргийн дүйцүүлэх алба хаах журам	Цэргийн албыг хааж байгаа иргэдийг орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд оролцуулах.	Хамрагдсан хүн	Тоо	2023	80	80	?	20.00	-	-	Энэ онд тус сумаас цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа 5 иргэн байгаа бөгөөд эдгээр иргэдийг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс 7 хоногийн хугацаатай хуваарьт газарт мод тарих ажилд дайчилсан. Сумаас цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байсан 5 иргэн 11 сард халагдсан. Үр дүнтэй 100%
18			Зөвсөгт хүчин, Хилийн цэрэг, Дотоодын цэргийн ангид алба хааж буй дайчидтай уулзалт зохион байгуулах, албаны үйл ажиллагаатай танилцах	Хамрагдсан хүн	Тоо	2023	100	300		20.00			Дотоодын цэргийн ангид алба хааж буй 8 цэрэгт гарын бэлэг бэлтгэн хүргүүлсэн. Энэ үйл ажиллагаанд Тамгын газрын төсвөөс 320000 төгрөг зарцуулсан. Үр дүнтэй 100%



 ХЯНАСАН
 ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
 ДАРГА П.ТОГТОХЖАРГАЛ
 ХЭРЭГЖИЛТИЙГ НЭГТГЭСЭН
 ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АСУУЛАЛ ХАРИУЦСАН
 МЭРГЭЖИЛТЭН *[Signature]* ЛАНГАА